



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/ЭНТ

Булган сум

Булган аймагт хийгдэх соёлын биет бус өвийн
бүсчилсэн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн соёлын биет бус өвийн бүсчилсэн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Алдармөнх (Соёл, урлагийн газрын дарга)

Гишүүд: Л.Одончимэг (Баяннуур сумын Засаг дарга)

П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)

М.Бадам (Бүрэгхангай сумын Засаг дарга)

Б.Дэлгэр (Гурванбулаг сумын Засаг дарга)

Д.Луттөмөр (Дашинчилэн сумын Засаг дарга)

Б.Мөнхбаатар (Могод сумын Засаг дарга)

Н.Амартүвшин (Орхон сумын Засаг дарга)

Б.Бат-Эрдэнэ (Рашаант сумын Засаг дарга)

Д.Сансар-Очир (Сайхан сумын Засаг дарга)

Н.Мөнхгэрэл (Хишиг-Өндөр сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Энхболд (Соёл, урлагийн газрын соёлын өвийн

асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Сум, орон нутгийн хэмжээнд соёлын биет бус өвийн судалгааны ажил хийгдэх хугацаанд судлаачдыг ажиллах нөхцөлөөр хангаж, дэмжлэг үзүүлэхийг ажлын хэсгийн гишүүд, судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Алдармөнх)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ